

Төслийн нэр: Эцэг эхийн оролцоот сургууль

Хэсэг I: Төсөл санаачлагчийн мэдээлэл

Аймаг/ хот: Булган
Сум /дүүрэг: Булган
СЭЭБХ-ны хаяг: Булган аймгийн Булган сумын ерөнхий болосролын 1-р сургууль, 313 тоот
СЭЭБХ-ны зохицуулагчийн овог, нэр: Алтангэрэлийн Буянбат

Хэсэг IIa. Нөхцөл байдлын шинжилгээ

Дотоод хүчин зүйлс	
<p>Давуу тал</p> <ol style="list-style-type: none"> 2012 оноос хойш тасралтгүй төрөлжсөн олимпиадын тэргүүн байрыг эзэлсэн бөгөөд сургалтын бусад үйл ажиллагаагаар аймагт тогтмол тэргүүлдэг шилдэг сургуулийн нэг. Бага ангийн ЗАН хамтран багаар ажиллах тэргүүн туршлагуудтай тул сурлагийн чанарыг ахиулах, эцэг эхийг аливаа үйл ажиллагаанд татан оруулах, тэдний хүч нөөцийг бүрэн дайчилан ажиллах боломжтой СЭЭБХ үйл ажиллагаа явуулах өөрийн байртай Аймгийн хэмжээнд явагдаж буй “Оюунлаг Булган” хөтөлбөр амжилттай хэрэгжиж байгаа 	<p>Сул тал</p> <ol style="list-style-type: none"> Сурлагын амжилтад нөлөөлөх хүчин зүйлс болон орчинг судалдаггүй. Эцэг эхчүүдэд хүүхэдтэй хэрхэн хамтарч ажиллах тэдний сэтгэхүйн онцлогийг хэрхэн таньж мэдэх талаар арга зүйн байхгүй. Багш болон эцэг эхчүүдийн хамтын үйл ажиллагааг тогтмол биш Бага ангийн багш нарын мэдлэг, ур чадвар харилцан адилгүй. Амжиргааны түвшин, эцэг эхийн боловсрол, ажил эрхлэлт харьцангуй бага Техник хэрэгсэл, хангамжийн хүрэлцээ бага учраас сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэхэд хүндрэлтэй байдаг
Гадаад хүчин зүйлс	
<p>Боломж</p> <ol style="list-style-type: none"> Бүх нийт боловсролын төлөө! ИНҮЭ болон СЭЭБҮНХ - хамтран түншилж ажиллах Харилцаа холбоо тогтоосон төрийн болон төрийн өмчит эрх бүхий 12 байгууллагуудтай хамтран ажиллах боломжтой Эцэг эхчүүдийн боломж нөөцийг ашиглах Сургуулийн захирал аймгийн ИТХ-н тэргүүлэгч бөгөөд амийгийн иргэдийн хурлаар санал, хүсэлтээ дэвшүүлэх Эцэг эхийн боломж нөөцийг ашиглах 	<p>Эрсдэл</p> <ol style="list-style-type: none"> Амьдралын түвшин, эцэг эхийн боловсрол, ажлын нөхцөл байдал зэргээс шалтгаалан эцэг эхийг татан оролцуулахад хүндрэл үүсэх Багшийн ажлын ачаалал их тул сайн дураараа цаг гарган ажиллахад бэрхшээл гарах

Хэсэг IIб. Төслийн зорилго, хамрах хүрээ

Зорилго	Бага ангийн сурагчдын эцэг эхийг авьяас, чадвараар нь бүлэг болгон сургуулийн үйл ажиллагаа, сургалтын үйл явцад туслуулах замаар сурлагын амжилтыг дээшлүүлнэ.
Хамрагдах хүний тоо	Бага ангийн 648 сурагч, тэдний эцэг эх, 21 багш, СЭЭБХ-ны гишүүд
Хүлээгдэж буй үр дүн	<ul style="list-style-type: none"> Эцэг эхчүүд өөрсдийн боломж нөөцөнд тулгуурлан сонирхлын бүлэг үүсгэж сургалтын чанарыг сайжруулах үйл ажиллагаанд сайн дураар оролцоно. Эцэг эхчүүд хүүхдийнхээ нас сэтгэхүйн онцлогийг мэдсэнээр тэдэнтэй хэрхэн зөв харьцаж ажиллах талаар ойлголттой болно. Эцэг эхчүүд хүүхэдтэй ажиллах аргачлалаас суралцана. Хүүхдээ сурч хөгжихөд нөлөөлөх сургуулийн орчинг судлан тулгамдаж буй

	<p>асуудлыг олж мэднэ.</p> <ul style="list-style-type: none"> • Зарим эцэг эхчүүд сургуулийн орчинд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхдээ сургуулийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд санал бодлоо тусган өөрийн биеэр оролцож сурна. • Сургалтын чанарыг нэмэгдүүлэх төслийн ажлын хүрээнд багшийн ёс зүй болон хандлага мөн эцэг эхчүүдийн сургууль ба хүүхдийн өмнө хүлээх үүрэг, хариуцлага улам нэмэгдэнэ.
--	--

Хэсэг III. Төслийг хэрэгжүүлэх зохион байгуулалт ба ажлын төлөвлөгөө

№	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн	Хугацаа	Хүрэх үр дүн
1.	Төслийн нээлтийн үйл ажиллагаа	СЭЭБХ, Сургалтад хамрагдсан эцэг эх, багш нар	2019 оны 6-р сар	Аймгийн хэмжээнд эцэг эх, иргэд, байгууллагуудыг урина. Төслийн үйл ажиллагааг таниулна.
2.	Бага ангийн сурагчдын эцэг эхээс судалгаа авах	СЭЭБХ, БАЗАН	2019.9-р сар	Эцэг эхийн дунд мэргэжил, авьяас чадвар, сонирхлыг тодорхойлох асуулга бэлдэж судалгааг авна. Мөн хүүхдийнхээ сурах үйл явц, сургуулийн үйл ажиллагаанд ямар байдлаар туслах боломжтой гэдгийг нээлттэй асуултаар тодруулна.
3.	1-5-р ангийн бүлэг бүрийн эцэг эхийн уулзалт зохион байгуулна.	БАЗАН, СЭЭБХ, Сургуулийн удирдлага	2019.9-р сар	Уулзалтаар СЭЭБХ төслийн үйл ажиллагаа зорилгыг танилцуулж, судалгааны дүнд үндэслэн эцэг эхчүүдийг сайн дурын үндсэн дээр багт хуваана.
4.	Бүлэг бүрийн эцэг эхийн баг төслийн туршид зохион байгуулах үйл ажиллагаагаа төлөвлөнө.	СЭЭБХ, БАЗАН	2019.9-р сар	1-р ангийн эцэг эхийн баг “Авьяас” баг – өөрсдийн авьяасаар нэгдсэн эцэг эхчүүд бага ангийн сурагдах зориулсан 2 дугуйлан хичээллүүлнэ. 2-р ангийн эцэг эхийн “Мэдрэмж” баг – Бага ангийн сурагчдын сурлагад нөлөөлдөг Сэтгэл зүйн орчны хүчин зүйлсийг тодорхойлох арга зүй боловсруулна. 3-р ангийн эцэг эхийн “Чадвар баг” – гарын доорх материалыг ашиглан монгол, математикийн хичээлийн хэрэглэгдэхүүн хийнэ. 4-р ангийн эцэг эхийн “Чанар” баг – Дотуур байрны сурагчдын сурах үйл явцад өөрсдийн чадах зүйлүүдээрээ туслана. Хичээл заах, ном уншиж өгөх, дугуйлан гэх мэт. 5-р ангийн эцэг эхийн “Нөлөөлөл” баг төслийн хүрээнд өрнөж байгаа бүх үйл явцыг аймгийн хэмжээнд сурталчилна. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон сургалт сурталчилгаагаар таниулна.

5.	1-р ангийн эцэг эхийн баг “Авьяас” багийн үйл ажиллагаа	СЭЭБХ, багийн эцэг эхчүүд, сургуулийн удирдлага	2019.10-р сараас	2 төрлийн дугуйланг хуваарийн дагуу тогтмол хичээллүүлнэ. Сонирхсон бүх хүүхэд хамрагдах боломжтой байхад анхаарна.
6.	2-р ангийн эцэг эхийн “Мэдрэмж” баг – Бага ангийн сурагчдын сурлагын амжилтад нөлөөлдөг Сэтгэл зүйн орчны асуудлыг тодорхойлох арга зүйг бэлтгэх	СЭЭБХ, багийн эцэг эхчүүд, сургуулийн удирдлага	2019.04-06 сар 2019.10-р сараас	Арга зүйг боловсруулахад шаардлагатай сургалт, уулзалтуудыг зохион байгуулж, аймгийн ГБХЗХГ болон бусад төрийн бус мэргэжлийн байгууллагуудаас зөвлөгөө тусламж авах, интернэтээс мэдээлэл цуглуулах замаар арга зүйг боловсруулна.
7.	Сурлагын амжилтанд нөлөөлөлх сэтгэл зүйн орчны хүчин зүйлсийг тодорхойлох аргачлалыг турших	СЭЭБХ, Багийн гишүүд	2019.10-р сараас	Нийгмийн ажилтантай хамтран бүлгийн ярилцлагууд зохион байгуулна.
8.	Багийн дүгнэх уулзалт	СЭЭБХ, Багийн гишүүд	2019.10-р сараас	Аргачлалын явцад гарсан ажигласан нийтлэг зүйлүүдээ тэмдэглэж, асуудлаа нэгтгэнэ.
9.	3-р ангийн эцэг эхийн “Чадвар баг” – гарын доорх материалыг ашиглан монгол, математикийн хичээлийн хэрэглэгдэхүүн боловсруулна.	БАЗАН, СЭЭБХ, Багийн гишүүн эцэг эх	2019.10-р сараас	Эцэг эхчүүдийн хийсэн бүтээлээр хичээлийн хэрэглэгдэхүүний цомогтой болж, эцэг эх хүүхэдтэйгээ гэрээрээ ашиглана.
10.	4-р ангийн эцэг эхийн “Чанар” баг – Дотуур байрны сурагчдын сурах үйл явцад өөрсдийн чадах зүйлүүдээрээ тусална. Хичээл заах, ном уншиж өгөх, дугуйлан гэх мэт.	Дотуур байрны багш, СЭЭБХ, Багийн гишүүн эцэг эх	2019.10-р сараас	Дотуур байрны багштай хамтран хүүхдийн хэрэгцээнд нийцсэн, эцэг эхийн чадварт таарсан үйл ажиллагааг төлөвлөж, хуваарь гарган үйл ажиллагааг өрнүүлнэ.
11.	5-р ангийн эцэг эхийн “Нөлөөлөл” баг төслийн хүрээнд өрнөж байгаа бүх үйл явцыг аймгийн хэмжээнд сурталчилна. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон сургалт	БАЗАН, СЭЭБХ, Багийн гишүүн эцэг эх	2019.10-р сараас	Төслийн үйл явцыг баримтжуулсан матеиралуудтай болохоос гадна цуглуулсан материалыг ашиглан аймгийн удирдлагуудтай дугуй ширээний ярилцлага, нөлөөллийн уулзалтуудыг зохион байгуулсан байна. Дээрх багуудын хийсэн ажлын үр дүнг сурталчилна.

	сурталчилгаагаар таниулна. Аймгийн удирдлагуудад хүргэнэ.			
12.	Сар бүрийн эцэг эхийн уулзалт	СЭЭБХ, Сургалтад хамрагдсан эцэг эх, багш нар	10 сараас эхлэн сар бүр	Зөвлөх багтай хамтран боловсруулсан аргачлалын дагуу сар бүр эцэг эхтэй тодорхой сэдвээр уулзаж хэлэлцүүлэг өрнүүлнэ. Зарим тохиолдолд сургалт хэлбэртэй ч байж болно. Төслийн төгсгөлд бүлэг бүр дор хаяж нэг удаа сургалтанд хамрагдсан байхаас гадна эцэг эхтэй тогтмол хамтран ажиллахаар зохион байгуулна.
13.	Төслийн дунд хугацааны үнэлгээ	СЭЭБХ	2019 оны 12-р сард	Төслийн дунд хугацаанд гарсан ахицаа үнэлж цаашид сайжруулах, дараагийн хичээлийн жилд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулна.
14.	Эцэг эхийн бүтээлийн үзэсгэлэн	Сургуулийн удирдлага, СЭЭБХ, багийн гишүүн эцэг эх	2020.4-р сард	5 бүлгийн эцэг эхийн төслийн хугацаанд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, бүтээлээр үзэсгэлэн гаргаж, олон нийтэд таниулна.
15.	Төслийн хаалтын үйл ажиллагаа, нөлөөллийн уулзалт	СЭЭБХ, Сургалтад хамрагдсан эцэг эх, багш нар	2020 оны 4-р сар	Төслийн үр дүнг үнэлж, ахиц амжилтаа хуваалцахын зэрэгцээ Аймгийн БСУГ, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар болон бусад холбогдох төрин болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагуудыг урина.

Хэсэг IV Зардлын задаргаа

Зардлын төрөл	Хэмж их нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ, төг	Нийт үнэ, төг	Хүрэх үр дүн
1-р багийн үйл ажиллагааны зардал	Сар	10	60000	600000	2 төрлийн дугуйланг хуваарийн дагуу тогтмол хичээллүүлнэ. Сонирхсон бүх хүүхэд хамрагдах боломжтой байхад анхаарна.
2-р багийн үйл ажиллагааны зардал	Сар	10	60000	600000	Арга зүйг боловсруулахад шаардлагатай сургалт, уулзалтуудыг зохион байгуулж, аймгийн ГБХЗХГ болон бусад төрийн бус мэргэжлийн байгууллагуудаас зөвлөгөө тусламж авах, интернэтээс мэдээлэл цуглуулах замаар арга зүйг боловсруулна.

3-р багийн үйл ажиллагааны зардал	Сар	10	60000	600000	Эцэг эхчүүдийн хийсэн бүтээлээр хичээлийн хэрэглэгдэхүүний цомогтой болж, эцэг эх хүүхэдтэйгээ гэрээрээ ашиглана.
4-р багийн үйл ажиллагааны зардал	Сар	10	60000	600000	Дотуур байрны багштай хамтран хүүхдийн хэрэгцээнд нийцсэн, эцэг эхийн чадварт таарсан үйл ажиллагааг төлөвлөж, хуваарь гарган үйл ажиллагааг өрнүүлнэ.
5-р багийн үйл ажиллагааны зардал	Сар	10	60000	600000	Төслийн үйл явцыг баримтжуулсан матеиралуудтай болохоос гадна цуглуулсан материалыг ашиглан аймгийн удирдлагуудтай дугуй ширээний ярилцлага, нөлөөллийн уулзалтуудыг зохион байгуулсан байна. Дээрх багуудын хийсэн ажлын үр дүнг сурталчилна.
Хэвлэл мэдээлэл, сурталчилгаа	Удаа	2	70000	140000	Орон нутгийн мэдээллийн хэрэгслээр төслийн болон СЭЭБХ-ны үйл ажиллагааны талаарх сурталчилгаа хийх
Сар бүрийн эцэг эхийн уулзалт	Удаа	5	50000	250000	Аргачлалыг хэрэгжүүлэх явцад гарч ирсэн асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор уг уулзалтыг зохион байгуулна. Гэр бүлийн орчинд, эцэг эхийн зүгээс ажиллах хэрэгцээ шаардлагатай байгаа асуудалд нийцүүлэн бүлэг бүрийн эцэг эхтэй уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, эцэг эхийн хандлагад нөлөөлнө.
Эцэг эхийн сонирхлын бүлгийн уулзалт	Удаа	5	20000	100000	
Бага насны хүүхдийн сэтгэл зүй сургалт	Удаа	2	300000	600000	Мэргэжлийн багууллагатай хамтран сургуулийн эцэг эхчүүдэд мэдээлэл хүргэнэ.
Харилцаа холбооны зардал	Удаа	5	40000	200000	Оролцох нөлөө бүхий хүмүүст урилга хүргүүлэх, үйл ажиллагаа явуулах байр, газар бэлдэх, төслийн тогтвортой байдлыг бий болгоно.
Бичиг хэргийн зардал	Удаа	5	50000	250000	
Принтер	ш	1	500000	500000	
Ламинатор машин	ш	1	72000	72000	
Төслийн нээлт, хаалтын үйл ажиллагаа	удаа	2	100000	200000	Аймгийн удирдлагууд, БСУГ, бусад сургуулийн төлөөллийг урьж төслийн үйл ажиллагаа болон СЭЭБХ-ны үйл ажиллагааг танилцуулна.
Банкны шимтгэл				20000	Хаалтын үеэр төслийн гол үр дүнг танилцуулж, Сурлагын амжилтыг дээшлүүлэх арга зүйг бусад сургуулиудад түгээхэд нөлөөлж, сайн туршлагаа хуваалцана.
Бүгд				2666\$*2000=5 332 000	


Хэсэг VI Төслийн тогтвортой байдал

1. Жил бүр эцэг эхийн төлөөлөл сургуулийн гурвалсан орчинг судална.
2. Эцэг эхчүүд судалгааны үр дүнд гарч ирсэн асуудлыг сургууль, сум болон аймгийн хэмжээнд шийдвэрлүүлэх хүсэлтээ явуулна.

3. СЭЭБХ-с амжилт гарган ажилласан багш болон эцэг эхийн сайн туршлагыг орон нутгийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан түгээнэ.
4. Сонирхлын бүлгийн үйл ажиллагаа сайжирч бүлгийн тоо болон гишүүд нэмэгдэнэ.
5. Гэр бүл, Хүүхэд Залуучуудын Хөгжлийн Газарын мэргэжлийн сэтгэл зүйч болон “Гэр бүлийн боловсрол ” сэдэвт сургалт хариуцсан мэргэжилтэнүүдтэй хамтран ажиллаж сургуулийн эцэг эхчүүдийг шаталсан сургалтад ээлж дараалан хамруулна.

Төслийн саналыг дэмжсэн гишүүдийн гарын үсэг, нэр :

СЭЭБХ-ны Зохицуулагч: А.Буянбат /Гарын үсэг...../

<p>Төслийг боловсруулсан:</p>	<p>Эцэг эх / А. Санжаа / <i>Санжаа</i>..... // / С.Мягмарсүрэн / <i>С.Мягмарсүрэн</i>..... Багш /А.Буянбат / <i>А.Буянбат</i>..... /Б.Ундрах/ <i>Б.Ундрах</i>.....</p>	<p>Огноо: 2018 он 12 сарын 19 өдөр</p> 
-------------------------------	--	---